



ХVIII ЗУУНД ЭРДЭНЭ ЗУУ ХИЙДЭД ХИЙГДСЭН ИХ ЗАСВАР, ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛҮҮД

Х.Орхончимэг¹

¹ Их засаг их сургууль, Монгол улс
Цахим шуудан: orhonsi@yahoo.com

16 дугаар зууны сүүлч хагаст Монголд дэлгэрсэн бурхны шашин нь улс төр, нийгмийн харилцаанд гүнзгий нөлөө үзүүлж ирсэн бөгөөд энэ үеэс хойш Монголчууд бурхны шашны ертөнцөд хамаарах болсоныг түүх гэрчилнэ. Монголын бурхны шашны түүхийн судалгаа бол Монголын түүх судлалын нэг чухал сэдвийн нэг юм. Монголын түүх судлалд бурхны шашин дэлгэрч хөгжсөн түүхийн талаар судалгаа тодорхой хэмжээгээр хийгдэж ирсэн боловч тэр нь голдуу нийтэд нь товч тоочих хураангуй байдлаар бичиж ирсэн байна. Эрдэнэ зуугийн түүхээр бичигдсэн бүтээлүүдийг дурдвал: С.Пүрэвжав “Монгол дахь шарын шашны хураангуй түүх” УБ.1978, С.Ичинноров, Ч.Банзрагч “Эрдэнэ зуу хийд ба Түшээт ханы хошуу” УБ.2008, Н.Хатанбаатар, Ё.Найгал “Эрдэнэ зуугийн түүх” УБ.2005 зэрэг бүтээлүүдийг нэрлэж болох ч түүхийн баримт материалд тулгуурлан нарийвчилж, тусгайлан судлах шаардлага урган гарсаар байна. Ялангуяа Халхын бурхны шашны түүхийн тусгайлсан судалгаа өнөө хир хийгдээгүй билээ. Иймд Халхын бурхан шашны түүхийн судалгаа ялангуяа Эрдэнэ зуу хийдийн үүсч хөгжиж ирсэн түүхийг тусгайлан нарийвчилж судлах, энэ чиглэлийн судалгааг гүнзгийрүүлэхэд дэм өгөх үүднээс энэхүү өгүүлэлд Халхын бурхны шашны анхны хийд Эрдэнэ зууд ХVIII зуунд хийгдсэн засвар шинэчлэлтүүдийг тус хийдийн түүхэнд холбогдох гар бичмэл эхүүдэд

хэрхэн бичсэнийг тодруулан гаргахыг зорилгоо.

Эрдэнэ зуу хийдийг засаж сэлбэн шинэчлэх, их бага засвар хийх ажил 18 дугаар зууны эх буюу 1701 онд Эрдэнэ зуу хийдийн 3 дугаар цорж Лувсан Осорын үед эхэлжээ. 1730 оноос Эрдэнэ зуу хийдийн гадна талын шороон хэрмийг, 1743 оны харагчин гахай жил 2 дугаар богд Жибзундамба хутагт Эрдэнэ зууд залрах болсныг угтаж Түшээт ханы сангаас хөрөнгө мөнгө гаргаж Эрдэнэ зуу хийдийн хуучирч муудсан зүйлийг засан шинэчилжээ.

Энэ тухай сурвалжид “Цусаар бөөлжигч хэмээх харагчин гахай жилд умард зүгийн амьтны аврал Жибзундамба Лувсандамбийдонмэ бээр Лхүндүвтэчин Эрдэнэ зуу хийдэд залрах үед насны авшиг тэргүүтэн зарлиг номыг сонссон. Энэ үед Эрдэнэ зуу хийдийг сайтар засан сэлбэсэн”[1] хэмээжээ.

Эрдэнэ зууд дөрвөн их дарцагийг Түшээт хан, Өндөр гэгээн, бэйл Сэдшир нар босгожээ. Мөн Эрдэнэ зуугийн гурван зууг хувааж тахих санал өргөхөд Түшээт хан Гол зууг, Майдарын сүмийн хамт, Бэйл Сэдшир Зүүн зууг, Засаг Баарин Баруун зууг тус тус тахих болсон байна.

Энэ тухай сурвалжид “...Гал эр нохой жил цорж Лувсанданзан дөрөвдүгээр ширээнээ суулгаж ачит дархан цорж гэж дуудсан үед энэ гурван зуугийн сүмийг хуваан тахихаар гэгээн хан Гол зуугийн



сүмийг, Бэйл Сэдшир Зүүний сүмийг, Засаг Баарин Баруун зуугийн сүмийг нэг нэгээрээ тахин Гомбогүрийг тахисаны түмэн өлзий ба дөчин өрх байгуулж хурал жасын хэрэглэлийг бүтээлгэвэй. Эрхэй мэргэн хааны бүтээсэн Хонсим бодсадын сүм баруун суврагыг, зурхайч цоржийн байгуулсан Абтайн сүмийн сангаас тахижухуй зүүн суврагыг хан тахижухуй, Майдарын сүмийг Бэйл тахисанаас гадна дөрвөн аврага дарцагийг гэгээн хан, бэйл, засаг нар нэжгээд нэжгээдээр босгожээ.”[2] хэмээжээ.

1718 оны шар нохой жил Эрдэнэ зуугийн 5 дугаар Ганжирваа номч цорж Лувсанжанцан Очирваанын сүм байгуулж Өндөр гэгээний 85 сүүдэр зэрэгцсэн тул түүнийг Төгсбаясгалант хэмээн соёрхжээ.

Энэ тухай сурвалжид “Тавин долдугаар он шар нохой жил гэгээний өргөсөн зуугийн тавдугаар ширээний лам номч цорж Лувсанжанцан Очирдарийн сүм их ганжуур сэлтийг бүтээж тавин наймдугаар онд гэгээний наян таван сүүдэр дээр өргөсөнд сүмийн нэрийг Төгсбаясгалант хэмээн соёрхвой.” [3] хэмээжээ.

Өндөр гэгээний зарлигаар 1710 оны үед Эрдэнэ зууг байцаан үзэж зуугийн сүмийг шинэчлэх ажлыг эхлүүлж, хэрмийн хэмжээ, сүм дуганы тоог тогтоожээ.

Энэ тухай сурвалжид “ Богд эзэн сайшаан ерөөж Эрдэнэ зууг сайд гаргаж байцаан үзэж зуугийн сүмийг шинэтгэх ба хэрмийн хир болохыг хэмжээ тэмдэг талбиж, сүмүүдийн тоог авч мэдүүлвэй ”[4] хэмээжээ.

Сүмийн тоо чухам хэд орчим байсныг тодорхой тэмдэглэсэнгүй. Мөн энэ үед Сэцэн хан аймгийн цагаан даяанч хэмээх Лувсандамдин Авидын бурханы сүм тэргүүтэн 6 сүм, ганжуур болон бусад шүтээний хамт бүтээн анхдугаар богдод зориулан өргөжээ. Эрдэнэ зуугийн 3 дугаар ширээт лам Лувсан Осорын шавь Гэлэг Лүгэпил Авидын бурхан залсан нэгэн сүмийг байгуулан өргөжээ.

Энэ тухай сурвалжид “ ...Сэцэн хан

аймгийн даяанч хэмээх Гэлэг Лувсандамдин Авид бурханы сүм болон нийт зургаан сүм бүтээж, ганжуур ба бусад шүтээний хамт гэгээнд өргөхүй зуугийн гуравдугаар лам Лувсан Осорын шавь гэлэг Лүгэпил Авид бурхан залсан сүм нэгийг бүтээж гэгээнээ өргөжээ”[5] хэмээн тэмдэглэжээ.

1743 оны үед Эрдэнэ зуугийн 6 дугаар ширээт лам Түшээт ханы цорж билэгт Лувсанцэдэн “Шагмуун бурханы сүм байгуулж, Эрдэнэ зуугийн олон шавь нар бараа бологсод түүнийг урьдын зууг тахиж байсан уламжлалаар 1758 оны үе Гомбогүрийг Эрдэнэ зуугийн амин сахиус шүтээн гэж Жаягтаа оруулан Эрдэнэ зууд өдөр бүр 1000 шалсай, 100 цагаан үнээний сүү өргөж тахиж ёс тогтжээ”[6] хэмээжээ.

Энэ үеэс урьдын сүмчид буюу зуугийн сүм тахигчид сүмчин отог болон өргөжжээ. 5 дугаар цоржийн бүтээсэн Очирдарийн сүм хуучирч гэмтсэн учир 1759 оны шарагчин туулай жил 7 дугаар ширээт ламтан Лувсандагвадаржаа сэлбэн засуулжээ.

Энэ тухай 7 дугаар цорж ламтны төвдөөр бичсэн өөрийнх нь намтарт “ Хорин зургаан насныхаа согтууруулан үйлдэгч хэмээх шарагчин туулай жилийн (1759) хаврын адаг сарын шинийн нэгэнд Ганданшадавдамбапэлбийлэн хийдэд хэргийн учир алдрыг нь өгүүлбээс дээд ёнзон багш их хамба шашны эрхшээлийн эзэн зэрэг гэнэнгээс дараалан гэлэн санваарыг сайтар олжээ.өмнөх ганжуурва номт цорж нагац Лувсанжалцан бээр Очирдара тэргүүтэн адистадтай гурван шүтээнийг залж хийд нэгийг байгуулж дуусахад умард зүгийн шашны эрхшээлийн эзэн Жибзундамба Занабазар равнайж Ганданогминлин хэмээх алдар нэрийг хайрласан хийгээд сүм дуган жил өнгөрөх тутам хуучирч байсанд лам багш дээдэс бээр хийд үүнийг бид нар сэргээх хэрэгтэй мөн буй за. Үүгээр ч үл барам Эрдэнэ зуу хийдийн сүм дуган шүтээнүүд хуучирсныг сэргээх хүсэл байгаа хэмээн нийт шавь нартаа айлдан, сэргээх үед Очирдара бурхны дүрс хөргийн доодох

суудал сэнтийн доторхи гавал дамар, гавал эрхи, хонх очир байгаагаас үзэхэд дамар, гавал эрхи хоёр нь Богд Занабазарын гарын хэрэгсэл, хонх нь Донхор манзуширийн хэрэгсэл байсан юм. Эд бүгдийг сүм хийд шүтээнийг хуучрахад нь сэргээгч хэн болох тэр авах болой хэмээх бичиг байгаа тул лам багш дээдэс энэ бээр одоо сэргээгч бид нар мөн хэмээн айлдаад авч нямба бясалгалын хэрэгсэл болгоод хэн таарсанд гавалыг хүнд харуулалгүй нууж хадгалсан багаж хэрэгсэл нь одоо биднийх буй за. Сүм хийд шүтээнүүдийг сайтар сэргээж бас өөр шүтээнүүдийг нэмэн залаад равнайг дэлгэр үйлдсэн”[7] хэмээжээ.

Энэхүү сүмийг сэлбэн засах аргыг шашин ном дэлгэрэх учрал ерөөлөөр барьж сайн цагийн 1000 бурхан, сайтар урласан 21 дарь эх өргөн залж бодь суварга нэгийн дотор саж бумыг залжээ. Бас найман суварга бүтээн босгож равнайжээ. Лам нар хаад нийлэн 100 илүү лам хувраг хурах сүм нэгийг барьж, урьд нь ачит цоржийн дуганд хурж байсан өдөр бүрийн цогчин хурлыг түүнд шилжүүлэн хурах болжээ. Эрдэнэ зууд жил бүрийн өвлийн адаг сарын сүүлээр хангал, 29-ний өдөр сор залах, цагаан сарын шинийн нэгнээс арван нэгнийг хүртэл ерөөл хурна. Мөн 5-ны өдөр Майдар эргэж 16- ны өдөр тангараг өргөдөг байв. Ерөөлийн хурлыг Түшээт хан, ван гүн нараас хуруулна. Майдар цамын элдэв чимэг, их бага нэг зуун дөч гаруй хэнгэрэг зуу гаруйг бэлтгэнэ. Манал, Махгал, Гомбогүр бурхны сүм тус бүр нэгийг бүтээн барьжээ.

Энэ тухай 7 дугаар цорж ламтны төвдөөр бичсэн өөрийнх нь намтарт “...Эрдэнэ зуугийн ширээт ламд тушаасан түүний ачинд дулдуйдан би бээр Богд Зонховын шашинд тусыг горилсон сэтгэлээр хэдэн зуун шавь нарт хар шар олонд дурдах нь их хүрээний ёс журмын дагуу нэг манжаар цогчинд багтаан хураангуйлан байгуулж жил бүрийн арван хоёрдугаар сарын хорин тавнаас нийтийн ганшгийг уншуулж сор гаргах хийгээд цагаан сарын

шинийн нэгнээс арван нэгнийг хүртэл цагаан сарын их ерөөлөөр унших магтаал, хангал үндсүүдийг энэ хүрээний журмын дагуу бүгдийг шинийн арван таванд Майдар эргэх, арван зургаанд жайв данраг бас их дүйчэн гурав бүрдсэн өдөр, номын хүрдэн эргүүлсэн, тэнгэрээс буусан зулын хорин тавны өдрүүдэд ерөөл хурах болон тэдгээр тус бүрд зууд Дончид өргөх ёсыг байгуулсан. Сүм дуган гурван шүтээн луга сэлтсийг босгохын зүйлд Богд Занабазарын зарлигаар Ганданогминлин хэмээх нэр хайрласан хуучин дуганы нэгийг шинээр бүтээсэн мэт сэргээсний дотор мянган бурхан зэрэг олон танх бурхад, хорин нэгэн дара эх тэргүүтэн суумал бурхан олон, Ганжуурыг гүнгэрва сэлттэй, бодь суврагны дотор буман сац найман суврага, нэг дуганы дотор Маналын поврон бурхад луга сэлт тэнд өдөр бүр Маналын доочиг хураангуй, жил бүр Маналын доочиг жайвыг долоо хоногоор өдөр шөнийн зургаан цагт үргэлж унших болгосон. Нэг дуганы дотор суумал Дорж Жигжид бурхан Гомбо Лхамуножинши, Балгон дон түүний гадна дотно нууцын шүтээн тангаргын зай, жансэг нугууд бүрэн тэнд жил бүр Гомбын дордүб жайвыг долоо хоногт бүтээн байгуулсан. Нэгэн дуганы дотор Гомбогүр тэргүүтэн Сажийн сахиусуудын гүнда, түүнд найм хоног Жэдор Гомбогүрийн хот мандал бүтээлийн тахилыг байгуулсан. Бас жил бүр Ядам, Дорж, Жигжид, Хорин нэгэн дара эх, Долоон гишүүнт мандалыг түм, сар бүр нунай, найдан тэргүүтний чогийг уншуулдаг болгов”[8] хэмээжээ.

Цаашид Эрдэнэ зуугийн сүм дуганууд хуучирч муудсан тул 1765 оны хөхөгчин тахиа жил номч цорж Лувсандагвадаржаа ламтнаас Чин ван Санзайдорж, Түшээт хан нарт сэлбэж засахыг дуртгасны улмаас зүүн зуугийн дуганыг засан шинэтгэхэд зарлигаар 1000 лан мөнгө гаргаж гүн Содномчоймболд даалган сэлбэн засуулжээ. Мөн үед Чин ван Санзайдоржоос ямандагийн сүм, Богд Зонховын сүм тус бүр нэгийг бүтээжээ.



Энэ тухай сурвалжид “... гучдугаар онд зуугийн сүмүүд их хуучирсан тул зуугийн долдугаар лам Номч цорж Дагвадаржаа бээр Ван Санзайдорж, Түшээт хан нарт сэлбэхийг дуртгаж өгүүлсэнээс уламжлан зүүн зуугийн сүмийг шинэтгэхэд зарлигаар мянган лан мөнгө шагнаж Зонхов, Ямандагийн сүм энэ хоёрыг бүтээжихүй”[9] хэмээжээ.

Мөн Гол зуугийн сүмийг Түшээт ханы хатан Юнгэн Цогт Дарь түшмэдүүдтэй хамтран 1768 оны шар хулгана жилийн зуны эхэн сарын гал могой цагт сэлбэн засаж эхэлсэн бөгөөд 1769 оны шарагчин үхэр жил дуусгаж 1770 оны барс жилийн 7 дугаар сарын 9-нөөс 11-ний өдөр Эрдэнэ бандид хутагт Жамбалдорж удирдан зуу илүү хувраг равнай ёслол үйлдэж нээжээ.

Энэ тухай сурвалжид “...Гол зуугийн сүмийг Түшээт ханы Юнгэн Цогт Дарь, түшмэд сэлт бээр гучин гуравдугаар он хулгана жил зуны эхэн сарын гал могой цагт эхлэн сэлбэж шар эм үхэр жил намар сэлбэн дуусгаад төмөр шар барс жилийн долдугаар сарын шинэдээр Эрдэнэ бандид Жамбалдорж лам бээр нэг зуу илүү хувраг луга хамт равнай ёслол үйлдэв”[10] хэмээжээ.

Мөн үед Гэлэн даяанч эрхлэн сүсэгтэн олны хамтаар Бурхадын сүм, Хүрдний сүмийг тус тус Богд гэгээн болон хаанд зориулан байгуулжээ.

Энэ тухай сурвалжид “...Гэлэн даяанч эхлэн урд хожидын сүсэгтэн лам нар бурхадын сүм ба хүрдний сүм бүтээж заримууд нь гэгээнээ заримууд нь хаанд барьсан буй”[11] хэмээжээ.

Эрдэнэ зуугийн цогчин хурлын дуганыг 1771 онд 7 дугаар ширээт лам номч мэргэн цорж Лувсандагвадаржаа бүтээн бариулсан байна. 7 дугаар цорж ламтнаас “цогчин хурах их дуган байгуулья” хэмээн Түшээт хан Цэдэндоржид айлтгасанд “Хантан таны хүчин хүрэхгүй буй за” хэмээн хариу өгсөн боловч цорж ламтан зориг мөхсөнгүй ихэс дээдэс олон хүнтэй учирч, Цэцэн хан аймгаар явж өглөгийн эзэд олноор цугларч

мөнгө эд мал тэргүүтнийг өгч, их дуган барих ажил эхлэн уран дархчуул олноор ирж барьж дуусгажээ. Тэр цогчин дуганы буурь өдгөө Абтай сайн ханы гэрийн буурины хойд талд байна.

Цогчин дуганыг хэрхэн барьсан тухай 7 дугаар цорж ламтны төвдөөр бичсэн өөрийнх нь намарт “...Гучин зургаан насны харшлагч хэмээх шарагчин үхэр жил (1769) нааш морилж их хүрээ Рэвогэжайлан хийдэд заларч богд Жибзундамба Ишдамбийнямын гэгээнд мандал өргөж бараалхав. Жибзундамба түүнд гурван үүдний их бишрэлээр залбирсны үрэнд Эрдэнэ зуу хийдэд цогчин их дуган нэгийг шинээр бүтээхийн соёрхлыг айлтгасанд цаглашгүй нигүүлсээр болгоон баясан баясан зохиож зарлиг хайрласан.Дахин цогчин дуганыг босгохын үйл даруйдаа болон алс хэтгээ Эрдэнэ зуугийн шашны үйл нь хамбад аль нэгнээр харгалзах тул сайтар тэтгэх учир шалтгааныг нарийвчлан дэлгэрүүлж айлтгаад их хүрээнээс морилж Эрдэнэ зуу хийддээ буусан байна..... Тэндээсээ илжиж хэмээх цагаан туулай жил (1771) цагийн эрхээр дурлаачин цөөн тул Эрдэнэ зуу хийдэд тустай болов уу хэмээн таалаад Балдорж нагвучэнбу гүржий гомбо жамдал, лайжэ гомбуу бүүдара жамдал нугуудыг хавсран бүтээхийн эрхэнд үйлдэж тааллыг нь хангах, тааллыг нь машид дэлгэр орох амгалант сайтар тодорхой нэг урьдын олон төрөлдөө дадсаны ёсоор туурвин зохиожээ. Түүнээс өөрийн орны гэсгүй сайд, нярав, дахин урлах дархчуудыг дуудаад дуган босгох хэрэглэл, тоосго тэргүүтнийг зөвшилдөж одоо үед та нар бэлтгэлийг зөвлөлдөн ярилцахын зарлигыг хайрлаад их дуганыг бүтээх газрын зан үйл, газар авахыг сайтар үйлдээд лам багшийн заасны дагуу тэндээс эхэлж баясгалан хэмээх усан луу жилээс хэдэн жилийн дотор гүйцээн бүтээж лам тэр бээр равнай зохиосон”[12] хэмээжээ.

Иймээс Эрдэнэ зуугийн их цогчин дуганыг 1769 онд богд Жибзундамба хутагтад айлтган зарлиг буулгуулж,

дуганыг барих хөрөнгийг цуглуулсны дараа 1771 оноос барих ажлыг эхлүүлж хэдэн жилийн дотор дуусгасан бололтой байна.

Мөн тухайн үед Эрдэнэ зуугийн лам хувраг зуу орчим байсан тул “номч мэргэдийг олшруулж шашин хурлыг өргөтгөн дэлгэрүүлэе” хэмээн Түшээт ханд айлтгасанд зөвшөөрч таван гарын хурал болгосон байна. Мөн Эрдэнэ зуу хийд Сажагийн ёсны Гомбогүр уншсаар ирсэн бөгөөд эрхэм болох сахиусны авшиг, жонон уншлагын судар дэлгэрүүлэхэд хүнд байсан учир “зуугийн шашин өнө удаан дэлгэрэх учиртай” хэмээн жанжаа хутагт Ролбийдоржид учир шалтгааныг уламжилсанд “өөрийн төлөөний лам хуврагийг явуулах чухал” гэсний дагуу Түшээт ханы зөвшөөрлөөр 1775 оны хөхөгчин хонин жил Эрдэнэ зуугийн Чойжин гэсгүй Түшээт ханы Лувсан чогдов нарыг Түвд рүү явуулж Буддын шашны гэгээнтэн Дамбийжанцан лам тэргүүтнээс Гомбогүрийн зэрэг олон шүтээнүүдийг залж иржээ. Тэдгээр шүтээнүүдийн дотор дээд таван шашны хөрөг, цорж авга эрдэнийн цадиг хөрөг, их адистад чулуун махгал, сэтгэлчлэнгийн чандмань эрдэнэ, Гомбогүрийн жамгуур, Ядам Чойжингуудын олон хөрөг, Дээд таван шашны сүмбүм, хаан бадрах хэмээх судрууд, жанрайсаг хийгээд шашны гэгээний мутрын хошуу, Очир дамар, Эртний хувилгаан сэцэн ханы номын багш Пагва бурхан шагмунид болон хурмаст тэнгэрт өргөсөн номын цагаан лавай, баруун тийг эргэсэн бүрээ тэргүүтэн байжээ.

Энэ тухай сурвалжид “...Зуугийн хувраг урд зуу үл хүрэх тул номч лам бээр шажин хурлыг олон болгон дэлгэрүүлэхүй хэмээн санаж Түшээт хан лугаа зөвлөжСажавагийн ёсны Гомбогүр уншсаар байсан боловч эрхэм сахиусны авшиг, жонон уншлагын судар тодорхой үл байх тул тэр мэт нэгнийг олвоос зуугийн шашныг үргэлж орших тустай санаж Жанжаа Ролбийдоржийн гэгээнд урьдын

учир шалтгааныг айлтгасанд тэр мэт олох мөн боловч бусдаас олох арга үгүй чадваас өөрөө буюу эс чадваас өөрийн багш мэт нэгэн сайн хүнийг сажийн оронд илгээгээд сажагийн гэгээний сүмээс абшиг тэргүүтнийг гүйцэд олвоос сайн гэвээс Түшээт хан зөвшөөж дөчдүгээр он модон эм хонин жилд Чойжин гэвхүй, Түшээт ханы хошууны Лувсан чогдов хэмээх нэг Түвдийн орон ба ялангуяа сажийн оронд илгээн гучин тавдугаар сажийн гэгээн Дамбийжанцан тэргүүтэн лам нарын өмнөөс Гомбогүрийн ван жинон лүн тэргүүтнийг олж ирсэн. Бас адистад шүтээнийг хайрласныг нь залж ирсэн шүтээн дээд таван сажийн хөрөг, цорж авга эрдэнийн цадиг хөрөг, их адистад чулуун махгал, сэтгэлчлэнгийн чандмана эрдэнэ, Гомбогүрийн жамгуур, Ядам Чойжингуудын олон хөрөг, Дээд таван шашны сүмбүм, хаан бадрах хэмээх судрууд, жанрайсаг хийгээд шашны гэгээний мутрын хошуу, Очир дамар, Эртний хувилгаан сэцэн ханы номын багш Пагва бурхан шагмунид болон хурмаст тэнгэрт өргөсөн номын цагаан лавай, баруун тийг эргэсэн бүрээ тэргүүтэн буй” [13]хэмээжээ.

Мөн түүнчлэн амьсгал хайрлагч дун авчирч номч цорж Лувсандагвадаржаа ламтанд барьжээ. Бурхадыг залж ирсэн Чойжин гэсхүй Гомбогүр шүтээний ловон, номч цорж болж лам хуврагуудад ван гүн жонон хүртээн өгч, тэр ачит цорж Чойжин өөрийн хөрөнгө хүчээр Манзуширийн сүм нэг, Ямандагийн сүм нэг, Давхардаряар сүм нэгийг тус тус барьж Давхардаряар сүмийн дуганы дээд давхарт нь Ламанчогдов тэргүүтэй шүтээн олныг залжээ.

Энэ тухай сурвалжид “Амьсгал хайрласан дун тэргүүтэн залж ирээд номч цорж ламд барьсан буй. Мөн тэр Чойжин гэвхүй Гомбогүрийн шүтээний ловон талбиж тэр номч цорж лам болонловон энэ үед Манзуширийн сүм нэг, Ямандагийн сүм нэг, Давхардаряар сүм нэгийг тус тус барьж Давхардаряар сүмийн дуганы дээд



давхарт нь Ламанчогдов тэргүүтэй шүтээн олныг залбай”[14]хэмээжээ.

Мөнхүү Түшээт ханы хошуунаас Эрдэнэ зууд шашны номын сургууль байгуулах хүсэлтийг 7 дугаар номч цорж ламаар Банчин Эрдэнэ, Жанжаа хутагт нарт айлтгасанд Бодь мөрийн сургууль бясалгалд шамдваас сайн хэмээн зарлиг болсноор 1782 оны хар барс жил Эрдэнэ зууд тавин хувраг сурагчтай бодь мөрийн сургууль байгуулж байжээ.

Энэ тухай сурвалжид “...Түшээт ханы хошуу жич номч цорж лам бээр Банчин Эрдэнэ, Жанжаа гэгээн хоёрт Эрдэнэ зуугийн хийдэд сургууль алинд шамдваас шашин амьтаны тус их болохыг айлтгасанд мөн гэгээн бээр номын сургуулиас бодь мөрийн зэргийн бясалгалд шамдваас сайн хэмээн соёрхсон тул дөчин долдугаар он усан барс жилд Эрдэнэ зуугийн хийдэд тавин хувраг бодь мөрийн зэргийн сургууль байгуулав” [15]хэмээжээ.

Ийнхүү Эрдэнэ зуу хийдэд шашны гүн ухааны анхны гэж хэлж болох сургууль байгуулагдаж эрдэм боловсролтой лам нарыг сургуулиар бэлтгэж эхэлжээ.

Номч мэргэн цорж Лувсандагвадаржаа ламтан 1784 оны модон хөх луу жил урьд өөрийн бүтээн байгуулсан Махгал, Гомбогүр, Маналын сүмүүдийг өөрчлөн гурван давхар сүм бүтээж дээд давхарт нь таван махгал бүтээн тавьжээ. Дунд давхарт нь Гомбогүр, Махгал, таван хааны сүм байгуулж, доод давхарыг аймгуудын хурлын дуган болгожээ.

Энэ тухай сурвалжид “...Дөчин ёсдүгээр он модон луу жилд номч цорж бээр урьд өөрөө бүтээсэн Махгал, Манал, Гомбогүрийн сүмүүдийг Түвдийн хэлбэртэй гурван давхар сүм бүтээсэн. Дээд давхарт нь таван махгал бүтээн тавьжээ. Дунд гурван давхарын нэгэнд Гомбогүрийн сүм нэг, Махгалын сүм нэг, таван хааны сүм байрлуулж, доод давхарыг аймгуудын хурлын дуган болгож бүтээжихүй”[16] хэмээжээ.

Энэ нь Монголын уран барилгын

түүхэнд Төвд маягийн хэлбэртэй байшин баригдаж байсны илрэл юм. 1792 оны хар хулгана жил Эрдэнэ зуу хийдийн хуврагууд урьд барьсан гурван давхар сүмийн хойд талд Төвд хэлбэр загвартай хоёр давхар сүм бүтээж баруун дээд давхарт нь Жибзундамба хутагт өндөр гэгээний 16 дүрийг дүүшээр бүтээж залсан бөгөөд Богд Зонховын дүрийг мөн дүүшээр бүтээн залж ламирам Чойнхор хуруулжээ. Зүүн дээд талд нь алтан шармал Ямандагийг шүтээн залж, Доод давхарт нь 16 Найданжүдэг шүтээнийг залжээ. Энэ нь одоогийн Эрдэнэ зуу хийдийн Лавиран сүм мөн бололтой.

Энэ тухай сурвалжид “Тавин долдугаар он бүхнийг баригч нэрт усан эр хулгана жилд лам тэр бээр урьд бүтээсэн Махгалын гурван давхар сүмийн хоёр талд Төвд хэлбэртэй хоёр хоёр давхар сүм бүтээж баруун дээд давхарт Жибзундамбын гэгээний арван зургаан дүрийг туушаар бүтээн залвай. Доод сүмд Богд Зонховын эхийг туушаар урлуулж Ламрим Чойнхор хуруулж, зүүн дээд давхарт алтан шармал Ямандаг тэргүүтэн шүтээн залан доод сүмд арван зургаан Найданжүдэг тэргүүтэй шүтээнийг залвай”[17]хэмээжээ.

Эрдэнэ зуу хийдэд хутагтын орд хэмээх гурван давхар Ламрин Лувсандагвадаржаа бариулжээ. Түүнийг Оросын эрдэмтэн А.М.Позеднеев “Эрдэнэ зуугийн бүх барилга байшингийн дотроос хамгийн гол үзэмжтэй нь”[18] гэж тэмдэглэжээ.

1796 оны улаан луу жил Эрдэнэ зуугийн номч мэргэн цорж Лувсандагвадаржаа Түшээт хантай Эрдэнэ зуу хийдийн сүм дуганыг сэлбэн засаж шинэчлэх тухай зөвлөн ярилцаад Далай лам, Банчин богд, Жибзундамба хутагт, Түшээт хан, Сэцэн хан, Сайн ноён хан, Засагт хан, Хошой чин ван эрдэнэ шанзов, дөрвөн аймгийн бэйл, бэйс, гүн, засаг тайж, түшмэд, ард нарт айлтгал бичиж илгээсэн байна. Халх дөрвөн аймаг, Жибзундамба хутагтын шавь, Өөлд, Дүрвэд, Урианхай хошуу мал, хөрөнгө хандивласан байна. Эрдэнэ зуу хийдийг сэлбэж их засвар хийх талаар Хөх

хотын худалдаачин иргэн Буяндалай лугаа хэлэлцэн үнэ хөлс тохирон тогтжээ. Гурван зууг сэлбэхэд дотоод хэрэм буюу одоогийн улаан хэрмийг уужим болгож, гол зуугийн дуганы дээврийг хоёр давхар болгон, мөргөл хийх тойрууг томруулж, хазайсныг тэгшлэн засаж шаазан ваар тавьж орой дээр нь таван чи хэмжээтэй зэс дээвэртэй алтан шармал таван толгойтой бадамтай том очир босгожээ. Түүний үнэ хөлсийг 300 лан мөнгөөр тогтоож ганжуур өргөсөн байна. Мөн зүүн баруун хоёр зуугийн дуганд хоёр давхар дээвэр ваар тавьжээ. Махгалын сүм, Хонсимбодьсадын сүм, Майдарын сүмүүдийг ихэд зассан бөгөөд Далай ламын сүм, Цамбын сүм, Богд Зонховын сүм, Ямандагын 2 сүм, Аюушийн сүмүүдийг засаж, хаалга цонхуудыг нь шинэчилжээ. Мөн Абтай ханы бүтээсэн Далай ламын сүмийг давхар болгон шаазан ваар тавин шинэ алтан ганжуур босгож дээд давхарт нь Гомбогүрийн бүтээл хурал өдөр бүрийн жасаа гүрэм хурах журам тогтоожээ. Эрдэнэ зуугийн дөрвөн хүрдний сүмийг тоосгоор өрж ваарласан ба өнө мөнхийн зулын сүмийг шинээр барьж түүнд их таван толгой тахил гуулиар сийлсэн зулын том цөгц өргөж зул бадрааж, дөрвөн индрийн сүм барьж, чулуун арслан, барс, чулуун дарцаг цөгцийг тахижээ. Мөн гурван зуугийн шүтээн бурхад сэвтэж муудсаныг сэлбэн засуулж, гурван зуугийн дуган, бага сүмүүдийг алтан шанх тавин будаж, цогчин дуганд таван чи ганжир хийлгэж хуучин ганжирыг Очирдарийн сүмд босгожээ. Эрдэнэ зуугийн их засвар дууссаны дараа Эрдэнэ зуу равнайлах ёсыг гурав хоног үйлджээ. Энэ равнайлах ёслолд Зая бандидын 3 дугаар дүрийг урьж оролцуулсан байна.

Энэ тухай сурвалжид "... Сайшаалт ерөөлтийн тэргүүн онд Түшээт ханд номч цорж лам зөвлөн айлтгаж Далай лам, Банчин богд, Жибзундамба хутагтад бошго айлтгаж Эрдэнэ зуу хийдийг сэлбэюу мөн гурван зуугийн сүм ба олон сүмүүдийг шинэтгэж болох эм болохыг хүсэн номч тэр

бээр дүндэнгүүдийн соёрхол олоод их бага хутагт нар шавь нар, бэйл, бэйс, гүн засаг тайж түшмэд ард нарт сонсгон айлтгаж, Халх дөрвөн аймаг, Жибзундамба хутагтын шавь, Өөлд, Дүрвэд, Урианхайгаас гуйн олсон эд өлөг, мөнгө цай, бараа дөрвөн хошуу мал, хөрөнгөнөөс чармайн даган баясч энэ үйлийн хэрэглэлд зориулж хөх хотын худалдаачин Буяндалай хэмээх луга хэлэлцэж үнэ тогтон сэлбэхүүд урьдын зарлигын сайд хэмжээ талбигсан байдал ёсоор дотоод хэрмийг дотоод хэрмийг уужим болгож, гол зуугийн дуганы дээвэр хуучин нэг дээвэртэй бөгөөд нэмж хоёр давхартай болгон, тоосголож илжирсэн модыг авч хазайсныг тэгшлэн засч мод оруулж хоёр давхар дээвэрт нь шаазан ваар тавьж орой дээр нь таван чи хэмжээтэй зэс дээвэртэй алтан шармал таван толгойтой бадамтай том очир босгожээ. Түүний үнэ хөлсийг гурван зуун лан мөнгөөр тогтоож өгөөд. Гол зуугийн сүмд ганжир болгож өргөвэй. Зүүн зуугийн дуганд хоёр давхар байгуулж, тоосголож гол зуугийн адил болговоо. Махгалын сүм, Хонсимбодьсадын сүм, Майдарын сүмүүдийг ихэд зассан бөгөөд тавдугаар далай ламын сүм, цамбын сүм, богд зонховын сүм, ямандагын хоёр сүм, Аюушийн сүмүүдийг ихэд хуучирсныг засч гурав гурван хаалга цонхтой бүтээжээ. Жич Гол зуугийн үүдийг иргэн Буяндалай өөрийн сүгээр бүтээвэй. Бас Абтай ханы бүтээсэн гуравдугаар Далай ламын сүмийг давхар болгон шаазан ваар тавин шинэ алтан ганжуур босгож дээд давхарт нь Гомбогүрийн бүтээл хурал өдөр бүрийн жасаа гүрэм хурах дуган болговой. Хуучирсан дөрвөн хүрдний сүмийг тоосгоор өрж вааралвай. Мөн Далай ламын сүмийн хоёр талд хослон барьбай. Өмнө нь өнө мөнхийн зулын сүмийг шинээр барьж түүнд их таван толгой тахил гуулиар сийлсэн зулын том цөгц өргөж зул бадрааж, дөрвөн индрийн сүм барьж, чулуун арслан, барс, чулуун дарцаг цөгцийг тахижээ. Мөн гурван зуугийн сүм, цогчин дугана бага сүмүүдийг алтан шанх тавин будаж, цогчин



дуганд таван чи ганжир хийлгэж хуучин ганжирыг Очирдарийн сүмд босгож, мөн сүмд ваар тавьж Зая бандидын 3 дугаар дүрийг залж гурав хоног равнай үйлдвэй” [19] хэмээжээ.

Энд Эрдэнэ зуугийн их засвар өргөтгөл шинэчлэлийг ихэд тодорхой дэлгэрэнгүй бичжээ. Дээрхи Эрдэнэ зуу хийдийн их засвар шинэчлэлийн тухай мөн долдугаар цорж номч цорж Дагвадаржаагийн Төвдээр бичсэн намтарт мөн байна.

Энд өгүүлэхдээ “...Эрдэнэ зуу хийдийн гурван дуган голлолсон сүм дуган шүтээнүүд дөч гаруй, суврага хэрэм тэргүүтнийг олон жил удсаны эрхээр маш их хуучирсныг би сэргээюүдээ хэмээн таалж Эрдэнэ зуу түүний өглөгийн эздийн голлох нь болсон Халхын Очирай бат түшээт сайн хан Цэдэндорж, амбан Эпү Юндэндорж Эрдэнэ сэцэн далай Шанзадво Дамчаравжаа, дархан гүн Самдандорж бас их хүрээний хамба да лам тэргүүтэнд зарлиг зөвшлийг айлтгасанд тэдгээр ихэс лам, түшмэд хоорондоо ярилцан зөвшөөд умар зүгийн амьтны аврал Жибзундамбын гэгээнд бүтэх бүтэхгүйн зарлиг эшийг айлтгасанд Жибзундамбын гэгээнээс тэр мэт үйлдвээс сайн гэсэн зарлигийг хайрласныг бишрэн хүртээд Манжийн хаан Сайшаалт ерөөлт хаан суусан эхний жилд Эрдэнэ зуугийн хийд тэргүүтэн олон сүм дуган шүтээнүүд хэрэм хүрээ хуучирсныг нь сэргээсэн, шинээр босгосоныг Хөх хотын иргэн Буяндалай хэмээх Хятадтай хоёр түмэн мөнгөн лангийн мөнгөөр тохирч сэргээн засварлахыг эхлүүлсэн” [20] хэмээжээ.

Энд 7 дугаар цоржийн намтарт Эрдэнэ зуугийн их засварыг хийх зөвшөөрөл авсан тухай өгүүлсэн бөгөөд Эрдэнэ зуугийн өөрийнх нь гар бичмэл эхэд ямар ямар сүм дугануудыг сэлбэж шинэтгэн зассан тухай илүү тодорхой өгүүлжээ. 1799 оны шарагчин хонин жил 4 дүгээр Богд Жибзундамба хутагт Дондовваанчигжигмэджанцан гэгээний 25 сүүдэр зооглосон тухайд үлэмж лянхуа бататгах шашин амьтны тусын тулд номч цорж Лувсандагвадаржаа ламтны

айлдвараар Түшээт хан сүм барихаар бэлтгэж индэрийн дээр таван алд суварга нэгийг бүтээж дотор нь бурхан судар нэг бум таван түм таван мянга гаруй цац, нэг бум бурхан бодьсад, шар шашны зүйл адистад олныг агуулан бүтээжээ. Үүнд лам хуврагууд олноор оролцож суваргыг равнайлах ёслол гурав хоног үргэлжилж Чин сүжигт номон хан хутагтын 3 дугаар дүрийг залж байжээ.

Энэ тухай сурвалжид “... Номч цорж Дагвадаржаа лам бээрлүндэн буусан ёсоор дөрөвдүгээр он хэргийг бүтээгч нэрт шар эм хонин жил дөрөвдүгээр дүрийн Жибзунлуvsандондовваанчиг Жигмэджанцан гэгээний 25 сүүдэр зооглосон тухайд үлэмч лянхуа бататгах шашин амьтны тусын тулд бататгах номч цорж Лувсандагвадаржаа лам бээр урьдын Түшээт хан сүм барихаар бэлтгэж индэрийн дээр таван алд суварга нэгийг бүтээж дотор нь бурхан судар нэг бум таван түм таван мянга гаруй цац, нэг бум бурхан бодьсад, шар шашны зүйл адистад олныг агуулан бүтээжээ. Бас Чин сүжигт номон хан хутагтын 2 дугаар дүрийг залж гурав хоног равнай үйлдвэй” [21] хэмээжээ.

Үүний дараа 1802 оны усан хар нохой жилийн цагаан сарын шинийн нэгний өдөр Эрдэнэ зуугийн их сахиус Махгал бурханы шүтээнд алт мөнгө зэсээр урласан хохимой толгойн тэргүүний чимэг бүтээн өргөжээ. Дөрөв хоногийн дараа шинийн тавны өдөр мөнгөн чимэг бүхий хонх хийж 4 алтан луу зөрсөн хар магнаг торгон бүрхүүл хийж өргөжээ.

Энэ тухай сурвалжид “...Долдугаар онд номч лам тэрвээр их хэнгэрэг нэрт усан эр нохой жил сар шинийн нэгэнд зуугийн сүм доторхи их сахиусан цогт Махгалын биеийн шүтээнд алт зэс мөнгөөр урласан хохимой толгойн тэргүүний чимэг их шүр сувд, тэргүүтэн эрдэнийн хасаар чимэглэн өргөөд шинийн тавны өдөр мөнгөн чимэг бүхий хонх хийж дөрвөн алтан луу зөрсөн хар магнаг торгон бүрхүүл хийж тавьсан нь насанд үл эвдрэх буй” [22] хэмээжээ.

Мөн 1799-1800 онд их хэрмийн гадна талыг иргэн Буяндалайгаар засуулжээ. Энэ үйл хэрэгт өглөгийн эзэд их тусыг үзүүлсэн тухай өгүүлсэн байна.

Энэ тухай сурвалжид “ ... долдугаар оноос наймдугаар он хүртэл иргэн Буяндалай бээр даалгаж лам хан зөвшөөрч өглөгийн эзэд чин сүсгээр гадуур их хэрмийг шинэтгэн сэлбээд шинэ тутам тавь гаруй суврага бүтээлгээд суврагны индэрт суврага бүтээсэн өглөгийн эздийн нэрс зэргийг чулуунд сийлж шигтгэсэн нь зуугийн өмнө хаалганаа баруун талаас эхэлж зөвшөөн өргөнө” [23] хэмээжээ.

Ийнхүү XVIII зуунд Эрдэнэ зуу хийдэд хийгдсэн засвар өргөтгөлийг Эрдэнэ

зуугийн түүхэнд холбогдох гар бичмэл эхүүдэд хэрхэн бичсэнийг тодруулан энэхүү өгүүлэлд дурдлаа. Эрдэнэ зуу хийдийг засаж сэлбэн шинэчлэх, их бага засвар хийх ажил 18 дугаар зууны эх буюу 1701 онд Эрдэнэ зуу хийдийн 3 дугаар цорж Лувсан Осорын үед эхэлжээ. Эрдэнэ зуу хийдийн Гол зууг барьснаас хойш Эрдэнэ зууд 60 гаруй сүм, 108 суварга, 500 гаруй барилга барьсан байна. Мөн эдгээр сүм суварга барилгуудыг сүсэгтэн ард олны өргөлөөр байнга засан сэлбэж өргөтгөж байсныг Эрдэнэ зуугийн түүхийг бичсэн гар бичмэл эхүүдэд тодорхой тэмдэглэсэн байна.

ДҮГНЭЛТ

XVIII зуунд Эрдэнэ зуу хийдэд хийгдсэн их засвар, өргөтгөл, шинэчлэлүүдийг Эрдэнэ зуугийн түүхэнд холбогдох гар бичмэл эхүүдэд тулгуурлан бичиж дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. XVIII зуунд Эрдэнэ зуу хийдийг засаж шинэчлэх ажил тасралтгүй хийгдэж байсан ба энэхүү засан шинэчлэх ажлыг сүсэгтэн олны өргөл хандиваар тасралтгүй хийж байжээ.

2. XVIII зуунд Эрдэнэ зууд засвар өргөтгөл хийж байсны зэрэгцээ хэд хэдэн онцлог үйл явдлууд болж байсан байна. Тухайлбал 1782 оны хар барс жил Эрдэнэ зууд тавин хувраг сурагчтай Бодь мөрийн сургууль байгуулж байжээ. Энэ бол эрдэм номтой лам нарыг сургуулиар бэлтгэж

эхэлснийг харуулж байна.

3. Эрдэнэ зуу хийдэд шашны гүн ухааны анхны гэж хэлж болох сургууль байгуулагдаж ном бүтээл туурвих болжээ.

4. Номч мэргэн цорж Лувсандагвадаржаа ламтан 1784 оны модон хөх луу жил урьд өөрийн бүтээн байгуулсан Махгал, Гомбогүр, Маналын сүмүүдийг өөрчлөн гурван давхар сүм бүтээж дээд давхарт нь таван Махгал бүтээн тавьжээ. Дунд давхарт нь Гомбогүр, Махгал, таван хааны сүм байгуулж, доод давхарыг аймгуудын хурлын дуган болгожээ. Энэ нь Монголын уран барилгын түүхэнд Төвд маягийн хэлбэртэй байшин баригдаж байсны илрэл юм.

Ишлэл

- [1] Түгээмлийн эзэн хүрдний итгэл богд тойн Лувсандагвадаржаагийн намтар оршвой. Гар бичмэл эх. Эрдэнэ зуу хийдийн VII ширээт лам Лувсандагвадаржаа. Төвд хэлнээс орчуулсан гавж Ш.Сонинбаяр. УБ., 2011. т.17
- [2] Эрдэнэ зуугийн тухай. Монгол улс. ҮНС. Гар бичмэл эх. т.17. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Переводс монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной. Москва., 1999. 215
- [3] Эрдэнэ зуугийн тухай. Монгол улс. ҮНС. Гар бичмэл эх. т.18. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Переводс монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной. Москва., 1999. 216



- [4] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.18. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Переводс монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.1999.217
- [5] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.18. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Переводс монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.217
- [6] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т. 31
- [7] Түгээмлийн эзэн хүрдний итгэл богд тойн Лувсандагвадаржаагийн намтар оршвой. Гар бичмэл эх. Эрдэнэ зуу хийдийн VII ширээт лам Лувсандагвадаржаа.Төвд хэлнээс орчуулсан гавж Ш.Сонинбаяр.УБ.,2011.т.23-24
- [8] Түгээмлийн эзэн хүрдний итгэл богд тойн Лувсандагвадаржаагийн намтар оршвой. Гар бичмэл эх. Эрдэнэ зуу хийдийн VII ширээт лам Лувсандагвадаржаа.Төвд хэлнээс орчуулсан гавж Ш.Сонинбаяр.УБ.,2011.т.53-54
- [9] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.20. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.222
- [10] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.20. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.222
- [11] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т. 21. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.222
- [12] Түгээмлийн эзэн хүрдний итгэл богд тойн Лувсандагвадаржаагийн намтар оршвой. Гар бичмэл эх. Эрдэнэ зуу хийдийн VII ширээт лам Лувсандагвадаржаа.Төвд хэлнээс орчуулсан гавж Ш.Сонинбаяр.УБ.,2011.т.33-34
- [13] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т. 21-22. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Переводс монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.223-224
- [14] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.22. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999. 224
- [15] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.22. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.224-225
- [16] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.23. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.225
- [17] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т. 27. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.230
- [18] А.М.Позеднеев. Монголия и Монголы.спб.т.1.1898
- [19] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.гар бичмэл эх.т.27-29. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.231-233
- [20] Түгээмлийн эзэн хүрдний итгэл богд тойн Лувсандагвадаржаагийн намтар оршвой. Гар бичмэл эх. Эрдэнэ зуу хийдийн VII ширээт лам Лувсандагвадаржаа.Төвд хэлнээс орчуулсан гавж Ш.Сонинбаяр.УБ.,2011 он.т.54
- [21] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.27-29. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999.236-237
- [22] Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т. 30. История Эрдэни-Дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения



- [23] А.Д.Цендиной.Москва.,1999.237
Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх.т.31. История Эрдэни-Дзу.
Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения
А.Д.Цендиной.Москва.,1999.239

Ашигласан бүтээлийн жагсаалт

Эх сурвалж

1. *Эрдэнэ зуугийн тухай.Монгол улс.ҮНС.Гар бичмэл эх*
2. *Эрдэнэ зуу ба Өндөр гэгээний намтар оривой. ҮНС. Гар бичмэл эх*

Судалгааны зохиол

1. *С.Ичинноров, Ч.Банзрагч “Эрдэнэ зуу хийд ба Түшээт ханы хошуу” УБ.,2008*
2. *История Эрдэни-Дзу.Факсимиле рукописи. Перевод с монгольского введение, комментарий и приложения А.Д.Цендиной.Москва.,1999*
3. *С.Пүрэвжав “Монгол дахь шарын шашны хураангуй түүх” УБ., 1978*
4. *Түгээмлийн эзэн хүрдний итгэл богд тойн Лувсандагвадаржаагийн намтар оривой. гар бичмэл эх. Эрдэнэ зуу хийдийн VII ширээт лам Лувсандагвадаржаа.Төвд хэлнээс орчуулсан гавж Ш.Сонинбаяр.УБ.,2011*
5. *Н.Хатанбаатар, Ё.Найгал “Эрдэнэ зуугийн түүх” УБ., 2005*



ABSTRACT

**REPAIRS, EXTENSION AND REFORMS OF ERDENEZUU
WHICH WERE MADE IN 18TH CENTURY**

Kh.Orkhonchimeg

In this article, we have aimed to clarify about repairs, extension and reforms of ErdeneZuu which were made in 18th century. We have found out these materials in the manuscripts related to the History of ErdeneZuu.

This big repairs were made in the beginning of the 18th century that was the period of Luvsan-Osor with the title of 3rdTsorj/ monk who oversees religious functions in a temple /.

After the main temple named "Golzuu" of ErdeneZuu was built, there had been created more than 60 temples, 108 stupas and around 500 constructions.

While we have been finding out certainly about history of ErdeneZuu from some manuscripts, these temple and stupas were repaired and extended regularly with some pietists' offerings / believers/. Thus, we have aimed to clarify based on some historical facts how ErdeneZuu, Mongolian first center of Buddhism was repaired and extended.

Түлхүүр үг: *Эрдэнэ зуу, XVIII зуун, Сүм хийд, Номч Цорж, Шинэчлэл*